



ГЭРЭЭТ АУДИТОР СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВАХ ТУХАЙ

2021.06.24

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь ТАБ-ын 2019-2021 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий иргэнийг дараах ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байна.

Зарлагдсан ажлын байрны нэр, тоо: **Гэрээт аудитор - 1**

Тавигдах шаардлага:

- Нягтлан бодогч, эдийн засагч, эрх зүйч, хуульч мэргэжилтэй байж болно
- Магистр болон түүнээс дээш зэрэгтэй
- Компьютерийн өргөн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн
- Харилцааны болон багаар ажиллах ур чадвартай
- Ажлын ачаалал даах чадвартай
- Эерэг хандлага, чин сэтгэлтэй
- Судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэж байсан, түүндээ үнэлэлт, дүгнэлт өгч байсан бол давуу тал болно.
- Гадаад хэлний дунд түвшний мэдлэгтэй

Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Төрийн албан хаагчийн анкет
- Дипломын баталгаажсан хуулбар

Шалгаруулалтад оролцогчдын материалыг **2021.07.02**-ны өдрийг дуустал цахимаар болон цаасаар хүлээн авна.

Анкетын түвшинд тэнцсэн оролцогчдоос **2021.07.05**-ны өдөр сорил шалгалт авч, хамгийн өндөр оноог авсан оролцогч тухайн ажлын байранд тэнцэнэ.

Хаяг: Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2 дугаар байрны 2 давхарт

Цахим хаяг: **dornod@audit.gov.mn**

Холбогдох утас: 70584207, 99049828, 90109012

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР